

АРДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД БОДЛОГО: ХӨЛӨНБҮЙРЫН
БАРГА ХОШУУДТАЙ ХАРИЛЦСАН НЬ

Е.ДОВЧИН

Доктор, профессор, МУИС, ШУС, Нийсмийн Ухааны Салбар,

Улс Төр Судлалын тэнхим

Л.ОДЗАЯА

Докторант

Түлхүүр үг: Нарийн Монгол узэл. Ардын засгийн гадаад бодлога. Хөлөнбүйр, Барга

ABSTRACT: The new the People's government policy towards Hulunbuir's Barga' In this article after the establishment of new Mongolia the government have an special policy towards the Barga of Hulunbuir. In the foreign policy of new government had a special policy to the other Mongols which were separated from mainland Mongolia. Main goal of it was reunification of the rest mongolia which was proclaimed since the restoration of all mongolia in 1911. The new government have continued that policy which was stopped during the previous government by Russia and China pressure. Such archive materials I found and described in this article in case of the policy towards the Barga of HULUNBUIR and will agree if they will reunited.

ХХ зуны эхний 20-иод жилд Монголын түүхэнд тохиосон хоёр том хувьсгал болох 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал болон 1921 оны Үндэсний хувьсгалын чухал зорилт бол олон монголчуудаа нэгэн туурга дор нэгтгэхэд оршиж байв. Манай түүх бичлэгт 1911 оны хувьсгалын дараа нийт монгол овогтноо нэгтгэхийн төлөө хийсэн тэмцлийг аль нэгэн талаас нь судлан бичсэн бүтээлүүд нэлээд гарчээ. Мөн эл хэрэгт холбогдох түүхэн эх сурвалжуудыг нийтийн хүртээл болгож байгаа нь тус сэдвийг цаашид нарийвчлан судлахад зохих тулхэц егех нь дамжиггүй. Харин 1921 оны ардын хувьсгалын дараа тогтсон Хэмжээт цаазат Ардын эрхтэй засгаас гадаад бодлогын хувьд, тухайлбал Хөлөнбүйрын Барга, Алтайн өмнөд хязгаар, Тагна Тува зэрэг газар орны талаар ямар бодлого баримтлан хэрэгжүүлсэн талаарх судалгаа одоо хир хомс байна. Энэ нь манай улсын өмнөх тогтолцоо буюу социалист байгуулалтын жилүүдэд хилийн чанад дахь монгол овогтнуудын талаар судлан бичих явдал үзэл суртлын шалтгаанаар, тэр бүр хийгдэхгүй байжээ. Учир нь нийт монгол овогтноо нэгтгэх гэсэн хүсэл тэмүүлэл болгоныг Нармай үзэлтэн хэмээн буруушааж, улмаар ял шийтгэл оноож байсантай холбоотой байсан. Харин өнөө үед манай оронд ардчилал, ил тод байдал, түүхийн судалгаанд олон ургалч үзэл ноёрхоч болсон нь түүх судалыг үзэл суртлаас ангид, үнэн бодитоор нээн гаргах боломж олгож байгаа билээ.

Их гүрнүүдийн улс төрийн бодлогын улмаас Монгол улс газар нутгаа тануулсаны баримтууд болох Тагна Тувааг Орос 1914 онд Алтайн өмнөд хэсгийг 1913 онд мөн Хөлөнбүйрын Баргыг 1915 онд Дундад Иргэн улс өөрсдийнхөө эрхшээлд тус тус оруулсан байдаг. 1911 оны хувьсгалын нэгэн гол зорилт болж байсан нийт Монгол овогтноо нэгтгэсэн Их Монгол улс байгуулах гэсэн тэмцэл, хүсэл тэмүүлэл их гүрнүүдийн бодлого, хавчилтын улмаас бүтэлгүйтсэн билээ. Туурга тусгаар, өөрөө өөрийгөө эзэрхсэн Монгол улсыг 1915 оны Орос, Монгол, Хятад турван этгээдийн Хиагтын гэрээгээр Дундад иргэн улсын зээн эрхийн дор орших автономит эрхтэй улс болгож, түүний нутаг дэвсгэрийг Халх, Ховдын хязгаараар тогтоосон билээ.

1919 онд Монголын автономит засаг нуран унаж бөгөөд монгол нутаг харийн цэргийн эрхтнүүдийн түрэмгийлэлд нэрвэгдэж байсан хэдүй ч 1920-иод он болоход нийгмийн бүх анги давхарга хөдлөлгөөнд орж, улс орныхоо тусгаар тогтолыг дахин тусгаар тогтолцоо сэргээх арга замыг бололцооныхоо хирээр эрэлхийлэх болов. Улс төрийн хүчиний хувьд зохион байгуулалтад шилжиж байсныг илтгэх зүйл бол “Ноёдын нам”, “Түшмэдийн нам”, “Гадаад Монголын Автономи ба амгалан байдлыг хамгаалан туслах нам”, “Ардын нам” гэх мэт нам, эвслүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсан явдал юм. Тэдгээрийн улс төрийн байр суурийг тухайн үйл явдлын гэрч болсон хүмүүс бүтээлдээ хэрхэн бичиж дурьдсаныг эш үндэс болгон үзвээс дараах дүр зураг харагдаж байна. Үндэс:

-1917 онд Орос оронд бослого тэмцэл гарч засаг төрөө түлхэн унагааж, “хөрөнгө тэгшитгэх нам”-ынхан буюу улааныхан засгийн эрхэнд гарч ирсэнд Монголд улааны аюул нүүрлэж магад хэмээн эрх баригчдын зарим хэсэг ихэд балмагдан айж, эл асуудлыг Богд гэгээнд мэдүүлэн улмаар Улсын Дээд,

Доод хурлаар хэрхэн хэлэлцүүлж санал ихээхэн зөрөлдсний эцэст Хятадын талыг баримтлагч хэсэг нөхдүүдийн үйл ажиллагааны үр дунд автономит засгаа хэрхэн унагасан талаар Дилов хутагт Жамсранжав дурдатгал зохиолдоо дэлгэрэнгүй бичсэн байна. Түүний бичсэнээр Монголын автономит засгийн ганхлан Хятадууд түрэмгийлэн устгасан биш харин Монголын эрх баригчдын зарим хэсгийнхийн хүсэлтийн дагуу хятадууд цэргээ Монголд оруулжээ.

-Гэвч тус оронд хятадын гамин цэргээс ангижирч автономит засгаа дахин сэргээх гэсэн хүчинийний үйл ажиллагааны үр дунд гаминг хөөлгөхөөр цагаантан барон Унгерныг Монголд урин авчирсан тухай ахмад түүхч Н.Магсаржав бичиж үлдээжээ. Дахин сэргээгдсэн Автономит засаг богино настай байв.

-Харин Монгол орныг ихээхэн түйвээж байсан цагаантануудыг тус орноос хөөн зайлцуулах үйл хэргийг Ардын намынхан улаантнуудтай хамтран хийж гүйцэтгэсэн билээ. Харийн эрхшэлээс гарч тусгаар тогтолоо дахин зарлахын төлөөх тэмцэлд Ардын намынхны үйл ажиллагаа илүү явууртай байсны улмаас амжилтад хүрч. төрт улсаа голомт дээр нь сэргээн байгуулж чадсан билээ.

Ардын Засгийн Газар байгуулагдмагц цэрэг армийн хүчээ зуваатгаж улс орноо харийн түрэмгийлэгчдээс цэвэрлэх болон Монгол овогтныг нэгтигэх зорилго тавыж таван яам байгууленаас тухайн цаг үед Цэргийн яам онцгой үүрэгтэй байсан учраас Монгол ардын журамт цэргийг бүгд еренхийлэн захирах жанжин Д.Сүхбаатар болон Х.Чойбалсан. Чагдаржав, бэйс Сумъяа, Сундуйсүрэн, Н.Билэгсайхан тэргүүтэй хувьсгалын зүтгэлтнүүд Монгол улсын зүг бүрт журамт цэрэг элсүүлж, түүний зэрэгцээ цэргийн хэргэцээнд унаалга, хоол хүнсийг бэлтгэж ажилд онцгой анхааран хилийн харуулын занги нарт цэрэг, агт морьд яаралтай гаргаж ирүүлэхийг шаардсан бичиг явуулж байсан байна. Чингэхдээ ийм бичгийг Алтайн чанадад оршин сууж буй Хятадын Шинэ хязгаарт хамарагдах болсон монголчууд руу хүртэл явуулсан байна. Мөн дашрамд дурдахад Ардын засгийн газраас Тагна Тувагийн тусгаар тогтолыг огт хүлээн зөвшөөрөхгүй, тэднийг Монголтойгоо нэгтгэх гэсэн үйл ажиллагаа ч идэвхитэй явуулж байсан билээ.

Тулгар тогтсон Ардын засгийн газар өмнөд болон умард хөршийн мэдэлд орсон угсаа гарвал нэг олон жил нэгэн бүрэлдхүүнд байсан шашиш шүтлэг хийгээд бичигт үсэг нэгэн ижил овогтнуудаа алдсан явдалтай эвлэрэхгүй байжээ. Монгол овогтныг нэгтгэх ажлын хүрээнд Алтайн Урианхай Монгол хошуу. Тагна-Тува, Хөлөн буйрын Баргуудтай найрсаг харилцаа тогтоож, тэдгээрийг өөрийн улсын бүрэлдэхүүний нэг хэсэг хэмээн үзэж байсныг архивын баримтууд гэрчилж байна.

Ардын ардын засгийн газрын Монгол овогтноо нэгтгэх зорилгын хүрээнд хамгийн няйт бөгөөд найрсаг харилцаатай байсан нь Хөлөнбуйрын баргууд байжээ.

Баргууд нь Монгол угсаатны бүлгүүдээс ихээхэн өвөрмөц онцлогтой, ээдрээтэй түүхийг туулж, нутаглан суух газаргүй болоод одоогийн Хөлөнбуйрт ирж суурьшсан түүхтэй. Гэхдээ тэдний уг нутаг бол Монголын нууц товчоонд дурдсанаар Байгали нуурын өмнөд бие буюу амар мөрний хойд талаар байжээ.

Барга нэр нь Чин улсын Эеэр засагч хааны үед (1644-1661) Нерчүүгийн орчим ирж нутаглажээ. Улмаар Энх-Амгалан хааны 16 дугаар онд Халхын Түшээт хан, Галдан бошигт нарын тэмцлийн үеэр буюу 1684-1689 оны үеэр Орос. Чин улсын дайны хөлд дайрагдсан барга буриад нар тэвдэн сандарч харилсан зөвлөхөл санал зохицохгүй 3 хэсэг болон салсны: нэг хэсэг Оросын цагаан хааны харьяанд, хоёрдахь хэсэг нь Чин улсын харьяанд орж, гуравдахь нь Галдан бошготоос дүрвэж халхчуудтай Өвөр Монголын нутагт хүрээд дараа нь тэдний хамт Халхын нутагт буцаж ирж. Халхад захирагдах болжээ.

Эл үйл явдлын талаар Британика нэвтрхий тольд: XIII зууны эхэнд Баргужин төхөмд барга аймгийн холбоонд байсан баргууд Их Монгол улсын үед урагш нүүдэллэж их говиор нутаглаж байгаад Юан гүрний үед харуул хамгаалалт, цэргийн арын албыг хааж, Алтан хааны үед тэдний зарим нь Хөх нуур руу нүүдэллэж үлдсэн нь Халхын Сэцэн хан аймагт захирагдах болов хэмээжээ. 1734 онд Манжийн хаан Халхаас нүүсэн тэдгээр баргыг "Шинэ барга" хэмээн нэрлэх болж 8 хошуу, 40 сум зохиож Хайлаарын манж сайдад захириуулжээ.

Харин судлаач О.Оюунжаргал дээрх үйл явдлыг "Батмэнх даян хааны зургаан түмэнгийн нэг байсан Цахар нь Хунтайжийн үед Манжийн харьяанд орсон ба Цахар найман хошуу нь дан ганц цахар бус хорчин, урад, сенед, халх, барга нараас бурдэж байв" гэсэн нь түүхэн бодит байдалд илүү нийцж байна.

Ар Монгол Чин гүрний эрхшээлээс гарах тэмцэл өрнүүлж эхэлсэн тэр цаг үед Баргууд нь Хөлөнбуйрын нутагтаа тусгаар тогтонуулах талаар их үйл хэргийг эхлүүлсэн байжээ. 1911 оны 9 дүгээр сард Баргын ноёдын хурал болж Манж. Хятадын ноёрхлоос ангижрах асуудлыг сэм хэлэлцэн байна. Уг хурлаас гаргасан шийдвэрт: Баргаас хятадын түшмэдийг зайлцуулж. Хөлөнбуйрыг захирах эрхийг баргууд гартаа авах. Баргаас хятадын цэргийг зайлцуулах. Хятадын колоничлолыг зогсоож, баргад сууж

бүй хятуудыг баргын захиргааг хүлээн хэмээснийг нь захирах ба эс зөвшөөрөхийт нь хөөн гаргах, гааль татварын зэрэг бүх орлогыг Хөлөнбуйрын санхүүд авч байхार тогтсон байна.

Баргын ноёд өөрсдийн хэлэлцэн тохирсон эл шаардлагыг хятадын эрх баригчдад тавьсан боловч тэд эс зөвшөөрсөн байна. Иймээс тэд Ар Монгол тусгаар улс болж улмаар Монгол овогтноо нэгэн улс болгох тухай Халхын Хүрээний бүх хэргийг эрхлэн шийгтигэх газраас явуулсан бичгийг талархан хүлээн авчээ. Улмаар Хөлөнбуйрын Өөлдийн бүгдийн дарга Шэнфү тэргүүтэй ноёд 1912 оны эхээр хуралдаж, Их Хүрээнд байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрыг хүлээн зөвшөөрч, дагахаа илэрхийлэн төлөөлөгчөөр Солон хошууны бүгдийн дарга Цэндийг явууллахаар тогтсон ажээ. Үүнээс гадна Баргын Үндэсний эрх чөлөөний хеделгэөний зарим удирдагчид болох сумын занги Дамдинсүрэн, бичээч Гайхасу нарын 7 хүн баргуудыг төлөөлөн Нийслэл Хүрээнд хүрэлцэн иржээ. Тэд Богд хаан өргөсөн бичигтээ: *Богд хааныг эрдэнийн сууриндо залжсүүлэхэд явдлыг мэдэж, манай олон бүгдээр чин үнэнээр залбираад, түүмэд цэрэг цуглуулан, заан илгээж ирсэн бичгийг дагаж, харьят газрын хятаад түүмэл цэргийг өвлүүн дунд сарын 27-ний 1912 оны 1 сарын 15 нь өдөр нэгэнт хөөн гаргажэ, Богдын сурталд бараалхан одоож заан сургахыг хүлэсүгэй хэмээжээ.* Дагаар ирсэн Баргын ноёдод Богд хаанаас хишиг хүтээж нутаг орноо захирах Монгол улсын Соёмбөт тамгыг олгожээ.

Мөн Монголын засгийн газраас 1913 оны эхээр Дотоод яамны тэргүүн сайд чин ван да лам Цэрэнчимэд, бинт ван Гончигсүрэн нар Хөлөнбуйрт очиж газар орны байдал төлөвийг байцаан үзээд хятад цэргээс хамгаалж 1000 цэрэг нэмэн дайчилж газар орноо сайтар батлан хамгаалахыг даалгаж, бүгдийн дарга, дэд дарга, хошууны засаг, сумын занги, орлон хөөгч, аравны дарга наарт цалин олгож байх зэрэг шийдвэр гаргаж. Хөлөнбуйрын сайдууд, харьят газар алба хаах түшмэл, бичээч, зарлагын тоо ба тэдэнд олгох албан хэрэгцээний мөнгө, цалин, хувцасыг шинэчлэн төлөвлөснийг ёсоор болгон баталсан байна. Ийнхүү Монгол улсын засгийн газар Хөлөнбуйрт тусгайлан анхаарал хандуулж байжээ. Үндэсний төв Архивд хадгалгаж буй Гаалийн яамны данс хараанд Хөлөнбуйраас ирсэн гаалийн татварын мөнгийг хүлээн авсан тухай баримт ч нэлээд олон байна. Эдгээр нь тэр чухал цаг үед Монголын санхүүд оруулж байсан хувь нэмэр байв. Ийнхүү Хөлөнбуйрын баргууд Монгол улстайгаа нэгэн үе хувь заяагаа нэгтгэсэн юм. Гэвч Гурван улсын гэрээгээр Гадаад Монголын эзэмшлийн бус нутгийг 11-р зүйлд: “*Автономит Гадаад Монголын газар нутаг болбоос урьдах Хүрээний сайд, Улаастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд агсан газрууд бөгөөд өмнө зүг Дотоод Монгол, баруун өмнө зүгт Шинэ газар, баруун зүгт Илийн хязгаартай зааг нийлсэн Халхын дөрвөн аймаг ба Хөвдийн хязгаарын олон хошуудын хилээр буй амой*” гэж заажээ. Харин Монголын засгийн газар Гурван улсын гэрээг тайлбарлахдаа; “*Гурван этгээдээр тогтсон гэрээ бичигт: Автономит Монгол нь Улаастай, Хүрээ, Ховдын жанжны амбасын захирах хязгаараар хэмжээ болгооор дурьдсан зүйл буй боловч чухам хил хязгаарыг хувьсгасан зүйлгүй хэмээх байтгугай энэ заваар эрхэм улсаас бидний хүнийг арагдан хатган завсардуулах ба айлан сүрдүүлэх зэрэгээр гэрээ бичгийн хэмжээг эвдэлэн хатдах эрхийг эзэрхэн түйвээсэн зэрэг хэргийн улмаас бидний Монгол нэгэнт гагцаар тогтоноо үндсийг батлан хамгаалж өөртөө эзэрхэж эрхийг явуулан бүхийн дээр нэн шинэ хэрэгээс үүдсэн хэргийн үз эхэд холбогдон учир маш хөнгөнгүйгэснээс үзэхэд 1915 оны Гурван улсын гэрээгээр хөрш гүрнүүдийн тулгалтаар Хөлөнбуйрын барга хошууд Дундад Иргэн Улсын мужид харьялагдах болсныг үл хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын зорилтын санаа агуулагдаж энхүү 1915 оны баримтанд “*Монгол овогтны нэгтгэх*” гэсэн байр суурь цухалзаж байгаа нь плэрхий байна.*

Ингэж Баргууд нь Гурван улсын гэрээний дагуу Монгол улсын захиргаанаас гарсан хэдий ч тэдний зарим нь Монголд үлдэн амьдарч, ихэнх нь Хөлөнбуйр руу буцсан аж. Баргуудын удаа дараагийн нүүдлийн талаар судлууштай зүйл олон байдаг билээ.

1915 онд Монголд үлдсэн баргууд хожим нь буюу 1921 онд Автономит засаг дахин сэргэсний лараа Хөлөнбуйр руу ямар шалтгаанаар нүүсэн гэдэгт одоог хүртэл түүхийн судалгааны ном зохиолуудад дурдаагүй байдаг билээ хэмээн судлаачид бичсэн байна. Харин миний олж үзсэн архивын баримтанд: “*Хөлөнбуйрын мэйрэн зангийн яаднаас. Миний харьят Барга нараас Халх хошуу шавьд захиргаадсанас хойши албаны түшмэл цэрэг гаргаж хураалгасан зүйлгүй өөрсдийн дураар нүүж ирсэн хэмээх зэрэг олон учир гаргаж ирсэн гэсэн хэрэгт: Хөлөнбуйр газрын мээриний зангийн яамны бичиг. Энэ он цагаан сарын шинийн 8-нд эрхэм Монголын ард засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх газраас илгээн ирсэн бичигт эдүгээ Сэцэн хан аймгийг хамгаалан тохинуулах сайд Зүүн хязгаарыг батлан тохинуулах цэргийг дайчлан захирах сайд хичээнгүй баатар бэйсээс хүргэж ирсэн бичигт мэдүүлэн явуулан учир. Эдүгээ Сэцэн хан аймгийн Мантай баатар ван. Долсон нараас бидний сайдуудын тушаал хамтажж өргөн мэдүүлж, ирсэн хоёр зүйл бичигт өргөв. Зоргоор санаа үрважж явсан түүмэл ардүүдэг чангалан хурааж хошуу сумыг балартуулахгүй болгохыг гүйн мэдүүлэх учир. Байцааваас 7 онд Хөлөнбуйр газрын*

8 хошууны Хөөөт шар, Шүлүүн шарын олон хошуунаас манай харьяат нутагт нүүрэс ирээд түүмэл ард олонор тус тусын гарын усэг зурсан батлах бичиг гаргаж мэдүүлсэн нь: Бид нар язгуурын үндсийг дагажс. Богд хааны төр шашны соёлд дуртайяа шууд дагаж уул газар орны түүмэл ноёд зүй бус зүйт үзүүлээр хашраан зовоосон нь түйлд хүрсний учирт уг нутагт энэгээт буцахгүй таны харьяат хошуунд Үргд албат болж захицуулсугай хэмээн гүйн мэдүүлсэнд уламжлан зохих газарт өргөн мэдүүлснийг зарлиг гүйсан ёсоор болгох захицуулсан ба гээтэй улсын засаг халагдсан тухайд ийнхүү учир гаргаж өргөн мэдүүлсэнд мөн ёсоор болгон захицуулсан болгөө. Энэ өнөөрсөн жил харьяат нутагт гачаал зүй болсон түүл хөрөнгө малaa амьдроулахыг бодож нүүрээд хойши буцахын завсарт манай хошууны хамжлагын дарга бөгөөд тэргүүн зэрэг түүмэл Дашиамжил харьяат захиригааны нэлээд өрхийн хамт гэнэт зоргоор санаа урважс олон газрын ноёдод гүйэс хураан аваачих хүнийг гаргүүлж ирүүлээд урван явах байдлыг мэдээд түүмэл хураажс авчуулах албаны хүмүүсийг гаргаж явуулсанд тэд нарын хойши мэдүүлэн ирсэн нь очижэхэн бид нар тушаасныг дагажс хураахаар очоод буй атам мөн шөнө уул ноёдоос хураажс аваачмуу хэмээн түүмэлтийн хамт хорин хэдэн хүмүүс хүргэж ирээд буй амой гэжээ.

Үүний хариуд Ардын засгийн газар: "Ардын засгийн газраас Байцааваас мөнөөхөн цагийн самуунаас зайллан гарч, Халхын хошуу шавьд захирагдсан баргын харьяат түүмэд ардын дотроос эгэж одоон нэр бүхий түүмэд ард үнэхээрийн цагаан намын муу хулгай нарын самуунд тэсвэртэн чадахгүй зайллан зугтааж өөрсдийн дуртайяа уул нутагтаяа буцан одожс, орой төрөлдөө нийлэгдэн ахул манай засгийн газраас татгалзах зүйлгүй болов. ...Гагицуу манай ардын засгийн газар болгоос Халх, Дөрвөдийн зэрэг Монголчуудыг гадаад этгээдийн эрх мэдлээс ангийсруулан ард түмэнд эрх чөлөөг олгохыг гол болгох төдийгүй Хөлөнбүйр ба Өвөр Монгол зэрэг газрын Монголчуудыг нэгэн адил эзэрхэг харгисын дарлалаас эртхэнээ ангийсруулж, тус тусад чөлөө эрх олж Монгол язгууртан бүгдээр харилцан холбоо найрамдлыг батлан бататгажс нэгэн сэтгэл нийтийн хүчээр шар шашиш, үндэс язгуураа үүрд батлан хамгаалахыг туйлаас эрмэлзэн бүхий цаг болох юи гэжээ.

Энэхүү баримтыг үзвээс Ардын засгийн газрын эхний жилүүдэд цагаантан монголын баруун, зүүн хэсгээр байхдаа энгийн номхон ард иргэдийг зүйл бүрээр зовоож байнсны уршигаар Олноо өргөгдсөний эхний жилүүдэд Монголд дагаар орсон Баргууд арга буюу өөрсдийн уугуул нутаг руу буцааж нүүдэлэлсэн байна. Харин энэхүү явдлыг Ардын засгийн газар эрс эсэргүүцэж, Хөлөнбүйрүн мэйрэн зангиин газартай идэвхтэй харилцаж, харьяат баргуудаа буцаан авах хүсэлт илгээсэн хэдий ч тэдгээр нүүсэн баргуудын хүсэлтэнд үндэслэн тэднийг Хөлөнбүйрүн хошууны харьяат болохыг хүлээн зөвшөөрсний сацуу Хөлөнбүйр ба Өвөр Монголчуудыг ч мөн харийн дарлалаас эртхэн ангийсруулахыг хүсч байгаагаа ухуулан сэнхрүүлсэн байна.

Мөн дээрх баргуудын харьяатын асуудлаас гадна нутаг бэлчээрийн асуудлаар хоёр тал хэд хэдэн удаа албан захидал солиож байжээ. Тухайлбал, Зарлигаар зарсан Тамсагбулаг зэрэг газар сэргийлэх цэргийг захирах сайд гүн Бумшэндээс Монгол улсын Ардын засгийн газарт илгээсэн бичигт: "Мэдүүлэн явуулах учир. Эдүгээ Хөлөнбүйр газрын мэйрэн зангиин яамнаас хүргэж ирсэн бичгийн дотор Зүүн, Баруун гарын Шинэ барга найман хошууны нутаг гандажс өвс тачир сийрэг ургасан тул зах нийлэнд ийл засаг хошууны нутагт оруулан найртай ёсиг зузаатган түр нэгэн өвөл амьдроулан нутаглуулж дараа цаг оршиох тухайд хураамжлан аваачих зэрэг учрыг сийрүүлэн илгээн иржээ гэж дурдсаныас үзэхэд Хөлөнбүйрүн баргууд тусламж эрсэнд Ардын засгийн газар найртай хүлээн авч Хөлөнбүйрүн мэйрэн зангиин яамтай 1922 онд түр гэрээ байгуулж эл хэрэгт тусламж үзүүлэхээр болсон байна.

Эцэст нь дүгнэж үзэхэд Олноо өргөгдсөн Монгол улсад дагаар орсон Хөлөнбүйрүн баргууд Хиагтын гурван улсын гэрээгээр зарим нь Гадаад Монголд үлдэж, харин Хөлөнбүйрүн баргууд Дундад иргэн улсад захирагдах болсон билээ. Монгол улсад суурьшихаар үлдсэн баргуудыг Монголд үүрлэсэн цагаантнууд зүйл бүрээр зовоосны уршигаар Халхын нутгаас дүрвэн гарч, уугуул нутагтаяа буцан очиж, Хөлөнбүйрүн хошуудад захирагдах болсон хэдий ч Монгол улс болон Барга нь хоорондоо харилцаа холбоотой байж Хэмжээт цаазат Ардын эрхтэй засгийн газрын уед маш эв найрамдалтай байсан бөгөөд Монголын эрх баригчид элэг нэгт монгол ахан дүүсдээ дэмжлэг туслалцаа үзүүлж байсныг түүхэн баримтууд харуулж байна. Чингхэдээ зүгээр нэг дэмжих биш харин дээрх эх баримтанд дурьсанчлан: "тус тусад чөлөө эрх олж Монгол язгууртан бүгдээр харилцан холбоо найрамдлыг батлан бататгажс нэгэн сэтгэл нийтийн хүчээр шар шашиш, үндэс язгуураа үүрд батлан хамгаалахыг туйлаас эрмэлзэн" нэгэн үе явжээ.

НОМ ЗҮЙ

1. Н.Магсаржав. Монгол улсын шинэ түүх. УБ., 1994
2. Л.Дэндэв. Монголын төв түүх. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж. тайлбар нэрийн хэлээ хийсэн С.Чулуун. УБ., 2006
3. Ц.Пунцагноров. Монголын автономитын үеийн түүх(1911-1919). УБ.,1957
4. Онон Өргөнгөө. Asia's first Modern Revolution: Mongolia proclaims its Independence in 1911. New York. 1989.
5. А.В.Бурдуков. Хуучин ба Шинэ Монголд. УБ., 1987
6. Л.Жамсран, Монголчуудын сэргэн мандалтын эхэн. УБ.,1992, Монголын тусгаар тогтолын сэргэлт. УБ., 1997
7. Өргөдэй Тайван. ХХ зууны эхний Өвер Монголын улс төрийн хувьсалтын түүх Үхэр жилийн үймээний гэрэл. сүүдэр. Хөх хот 2011
8. Тачибана Макото. Монголын мартаадсан түүх. Богд хаант засгийн газар.(1911-1921). УБ., 2011
9. Лан Мэй Хуа. Монголын тусгаар тогтолын төлөө 1911 оны хөдөлгөөн: иэгдсэн Монгол улс байгуулах эрмэлзлэл. УБ., 2011
10. Монгол улсын автономи гэлэг өөртөө эзэрхэн засах эрхт засгийн үеийн үнэнхүү явдал чухам байдал, чухал учрыг тэмдэглэсэн төвч өгүүлэл гэлэг түүх бичиг. УБ.,1960
11. А.Очир нар. Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө. тусгаар тогтолын төлөө тэмцэл (1900-1914) Баримтын эмхтгэл. УБ., 1982
12. Ж.Гэрэлбадрах. Монголчуудын иэгдсэн улс байгуулахын төлөөх тэмцэл \1911-1915\ 3 боть Баримтын эмхтгэл. УБ.,2014
13. Дилав хутагт Б.Жамсранжав. Ар Монголын улс төрийн дурьдгал. УБ.,1992
14. Д.Сүхбаатар, Баримт бичгүүд. УБ., 1983. X.72
15. МАН-ын баримтын төв. X-4. Д-1. ХН-134, X.17-20
16. Ж.Өлзий. Барга Монголын түүх. УБ.,1999. X.41.
17. Британика. Боть I. УБ.,2011. X.327
18. О.Оюунжаргал. Манж Чин улсаас монголчуудыг захиран бодлого. УБ..2009. X.22
19. Н.Батболд. 1911-1945 оны Баргуудын харьяаллын асуудал. УБ..2012. X .9
20. Ж.Гэрэлбадрах. Монголчуудын иэгдсэн улс байгуулахын төлөөх тэмцэл \1911-1915\ Баримтын эмхтгэл. УБ.,2014. 1 боть. X.97
21. МУУТА.Х-2, Д-1, ХН-5
22. О.Батсайхан. Монголын тусгаар тогтол ба Хятад. Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. УБ 2011..X.226